



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/434

Мөрөн сум

Газрын талбайн хэмжээнд өөрчлөлт
оруулж, эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 1 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу 0.49879 га (49879м²) газрын газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2022 оны
12 дугаар сарын 28-ны өдрийн
А/434 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨХ
ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

№	Иргэндийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Өөрчилж, нэмэлт оруулж буй захирамжийн багана	Тайлбар
1	Богд овгийн Дамдин Дуламрагчаа /РС78082645/	6712017698	7-р баг 10-21 тоот	Сумын Засаг даргын 2006.04.20-ний өдрийн 54 тоот захирамжийн хавсралтын 30 дахь хэсгийн 3 дахь баганын талбайн хэмжээг "500м ² " гэснийг "767м ² " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /хэмжилтээр/
2	Мөрөн сумын Засаг даргын тамгын газар /РД:9070192/	Шинээр	1-р баг Стадионы ар талд	Аймгийн Засаг даргын 2021.03.31-ний өдрийн А/178 дугаар захирамжийн холбогдох хэсгийн талбайн хэмжээг "46951м ² " гэснийг "46422м ² " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /6712016524 нэгж талбарын дугаартай/
3	"Хөвсгөл геологи" ХК /РД:2034441/	Шинээр	1-р баг Гандан хороолол 203-5 байр	Аймгийн Засаг даргын 2020.05.04-ний өдрийн А/258 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалтын 7 дахь баганын талбайн хэмжээ "2160м ² " гэснийг "2690м ² " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /6712015963 нэгж талбарын дугаартай/

Нийт талбайн хэмжээ-49879м²



-----ооо-----